

2023 он 08 сар 01 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

**Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай**

Говь ХК-ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-ийг дахин сонгосугай.

**Хоёр.** “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

**Гурав.** Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, Эрсдэл аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д үүрэг болгосугай.

**Дөрөв.** “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-тай байгуулах гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, Санхүү хариуцсан дэд захирал /Б.Энхмандах/ нарт тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

20<sup>23</sup> он 08 сар 01 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**ХБНГУ дахь охин компанийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай**

Говь ХК-ийн ХБНГУ дахь охин компани болох “Говь Кашмер Европ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 6.3 дугаар зүйлийн 6.3.3.2 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн охин компани болох “Говь Кашмер Европ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Баатарсайхан овогтой Амарсайхан /РД:УШ98051239/-ийн хөдөлмөрийн гэрээг 2023 оны 08-р сарын 01-ний өдрөөр дуусгавар болгож ажлаас чөлөөлсүгэй.

**Хоёр.** “Говь Кашмер Европ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Цогтгэрэл овогтой Оргилболд /РД:ЙЮ90010932/-ыг 2023 оны 08-р сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

**Гурав.** Гүйцэтгэх захирлаар томилогдсон мөчөөс эхлэн Цогтгэрэл овогтой Оргилболд нь ХБНГУ-ын BGB хуулийн 181 заалтын хязгаарлалтаас чөлөөлөгдөн, ганцаарчлан бие даан компани төлөөлөх эрхийг хүлээж авахыг зөвшөөрсүгэй.

**Дөрөв.** Баатарсайхан овогтой Амарсайхантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах болон Цогтгэрэл овогтой Оргилболдыг “Говь Кашмер Европ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилохтой холбоотой үйл ажиллагааг Монгол улсын болон ХБНГУ-ын хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА